



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Могойн гол ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХӨА-2021/7/СТА-ОНӨААН

Цахим хуудас:
www.khuvsgul.audit.mn
2021 он

Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Ганболд
Утас: 99382500 Цахим хаяг: ganboldo@audit.gov.mn
Аудитын менежерийн албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг:
baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320 Цахим хаяг:
erdenechimegg@audit.gov.mn
Захирал: Б.Мядагмаа
Утас: 99389208
Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн Удирдах зөвлөл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4-5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8-9
4	9
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан	10
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13-14
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа.....	15
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.10. Аудитын илрүүлэлт	15
Залруулсан алдаа	15
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал.....	17-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20-21



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67123. Хөвсгөл аймаг. Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2021.03.15 № 01/372
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН "МОГОЙН ГОЛ" ХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
О.УУГАНБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Могойн гол" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Могойн гол" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төвийн гүйцэтгэлд материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. "Могойн гол" ХК нь 2020 онд 1,039.7 мян.м3 хөрс хуулалтын ажил хийж, 110.0 мян.тн нүүрс борлуулах зорилт тавьж 87.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

О.УУГАНБОЛД

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	80,596,465.28	146,272,287.03
1.1.2	Дансны авлага	350,667,391.97	290,640,137.70
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	22,798,893.00	13,269,989.37
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,963,773,734.49	3,769,174,445.62
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0	96,100,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	26,108,512.71	24,766,738.63
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,443,944,997.45	4,340,223,598.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,778,621,836.82	1,742,201,970.37
1.2.2	Биет бус хөрөнгө	27,397,320.75	125,466,800.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,806,019,157.57	1,867,668,770.37
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,249,964,155.02	6,207,892,368.72
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	451,141,444.51	262,740,965.55
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	300,689,257.49	337,835,466.54
2.1.1.4	НДШ - ийн өглөг	60,027,780.45	55,919,380.68
2.1.1.5	Богино хугацаат зээл	0	336,257,187.41
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	490,000,000.00	480,000,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		134,582,876.75
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	17,751,875.96	19,909,720.64
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,319,610,358.41	1,627,245,597.57
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	798,527,340.80	795,876,840.80
2.1.2.5			

**Могойн гол ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	798,527,340.80	795,876,840.80
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,118,137,699.21	2,423,122,438.37
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	42,310,722.00	42,310,722.00
2.3.2	хувийн	40,651,478.00	40,651,478.00
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	816,691,685.80	1,375,789,181.23
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	202,833,326.81	202,833,326.81
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,029,339,243.20	2,123,185,222.31
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,131,826,455.81	3,784,769,930.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,249,964,155.02	6,207,892,368.72

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,173,376,853.20	2,531,804,476.58
2	Борлуулалтын өртөг	2,114,019,646.59	2,119,004,198.90
3	Нийт ашиг(алдагдал)	1,059,357,206.61	412,800,277.68
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		45,261,775.31
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	355,342,614.03	283,207,341.62
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		67,265,742.15
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	747,962,199.48	107,588,969.32
19	Орлогын татварын зардал	74,796,219.95	10,758,896.93
20	Татварын дараах ашиг (алдагдал)	673,165,979.53	96,830,072.39
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	673,165,979.53	96,830,072.39
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	673,165,979.53	96,830,072.39
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	82,962,200.00		816,691,685.80	202,833,326.81	1,423,214,028.80	2,525,701,241.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-67,040,765.13	-67,040,765.13
Залруулсан үлдэгдэл	82,962,200.00		816,691,685.80	202,833,326.81	1,356,173,263.67	2,458,660,476.28
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					673,165,979.53	673,165,979.53
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	82,962,200.00		816,691,685.80	202,833,326.81	2,029,339,243.20	3,131,826,455.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-2,984,093.28	
Залруулсан үлдэгдэл	82,962,200.00		816,691,685.80	202,833,326.81	2,026,355,149.92	3,131,826,455.81
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					96,830,072.39	123,686,911.93
Зарласан ногдол ашиг						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			559,097,495.43			559,097,495.43
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	82,962,200.00		1,375,789,181.23	202,833,326.81	2,123,185,222.31	3,784,769,930.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,669,004,462.86	2,854,020,128.55
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,299,925,968.50	2,786,981,851.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	369,078,494.36	67,038,277.55
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,379,559,293.14	3,091,558,279.40
	Ажиллагчдад төлсөн	815,545,779.00	729,520,635.20
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	172,533,038.00	163,930,267.00
	Бараа материал худалданавахад төлсөн	947,755,661.00	745,298,966.00
	Ашиглалтын зардалд төлсөн	135,625,787.01	96,999,379.64
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,471,145,818.30	765,029,130.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	415,217,737.33	294,762,820.87
	Даатгалын төлбөрт төлсөн	3,305,340.0	80,431,175.00
	Бусад мөнгөн зарлага	418,430,132.50	215,585,905.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(710,554,830.28)	(237,538,150.85)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	303,759,000.00	
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	303,759,000.00	
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(303,759,000.00)	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		500,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		500,000,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		

Могойн гол ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

3.2	Мөнгөзарлагын дүн (-)	470,940,544.10	196,786,027.40
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		186,786,027.40
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	470,940,544.10	10,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааныцэвэр мөнгөн гүйлгээнийдүн	(470,940,544.10)	303,213,972.60
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,485,254,374.38)	65,675,821.75
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,565,850,839.66	80,596,465.28
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	80,596,465.28	146,272,287.03

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний
гүйцэтгэл**

/мян.төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
5	Нийт орлогын дүн	мян.төг	3,276,248.3	5,019,099.3	2,577,066.10	2,442,033.2	51.3
1	Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	3,101,213.5	4,922,000.0	2,531,804.40	2,390,195.6	51.4
2	Туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	72,163.4	50,000.0	0.00	50,000.0	0.0
3	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	70,635.5	0.0	0.00	0.0	
4	Халаалтын орлого	мян.төг	32,235.9	47,099.3	45,261.70	1,837.6	96.1
6	Нийт зардал	мян.төг	2,528,286.2	4,855,198.9	2,469,477.20	2,385,721.7	50.9
7	Нүүрсний борлуулалтын өртөг	мян.төг	1,748,805.2	3,893,687.2	1,847,421.00	2,046,266.2	47.4
8	Борлуулалтын зардал	мян.төг	223,948.6	179,306.1	169,095.00	10,211.1	94.3
9	Удирдлагын зардал	мян.төг	355,342.6	416,559.3	283,207.30	133,352.0	68.0
10	Туслах үйл ажиллагааны зардал	мян.төг	80,821.1	47,498.2	27,654.90	19,843.3	58.2
11	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	58,923.9	177,496.8	67,265.60	110,231.2	37.9
12	Уурын зуухны зардал	мян.төг	60,444.8	140,651.3	74,833.40	65,817.9	53.2
13	Нийт ашиг	мян.төг	747,962.1	163,900.4	107,588.90	56,311.5	65.6
14	Хөрс хуулалт	мян. м куб	1,003.8	1,039.7	1,040.50	-0.8	100.1
15	Олборлох нүүрсний хэмжээ	мян.тн	130.0	110.0	75.00	35.0	68.2
16	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	82.9	110.0	62.80	47.2	57.1

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарын хугацаанд Могойн гол ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч О. Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдэл, бараа материалын ангилалтай холбоотой, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, батлан мөрдөх, Сангийн яамнаас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан програм хангамжаар НББ-ийг хөтөлж тайлан гаргах, үйл ажиллагааны бус зардлыг татварын өмнөх ашгийг нэмэгдүүлж орлогын албан татварын зардлыг төлөвлөх, авлага өглөгтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 25-аас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/82 дугаар тушаалыг үндэслэн Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газартай 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр "Санхүүгийн тайлангийн аудитын ажилд шинжээч ажиллуулах" 2020/12 тоот гэрээ байгуулсны дагуу ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э. Бат-Эрдэнэ нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Ганболд хоёр дахь шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа, аудиторовын туслах Ж.Уранчимэг нар аудитыг гүйцэтгэж, захирал Б.Мядагмаа чанарын хяналтыг хэрэгжүүлэв.

Могойн гол ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 51 хувийг Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 49 хувийг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

Могойн гол ХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсад ашигт малтмалын хайгуул, олборлолт хийх болон хэрэв боломжтой гэж үзвэл боловсруулах
- Ашигт малтмалыг боловсруулах, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдах худалдан авах импортлох, экспортлох зэргээр гадаад дотоод худалдаа эрхлэх
- Монгол улсын хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Нийгмийн даатгалын тухай хууль /шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт/

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Могойн гол ХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага 2014 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа тул холбогдох стандарт, хууль тогтоомжийн шинэчлэлтэй нийцүүлэх шаардлагатай байна.

Тайлант онд тус байгууллагын 2018, 2019 оны үйл ажиллагааны үр дүнд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийсэн байна. Нийт 4,439,000.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 4,439,000.0 мянган төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсний 7 зөвлөмж нь “Могойн гол” ХК-д бусад зөвлөмжийг ТУЗ, Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өгсөн байна.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн дотоод хяналтыг хэрэгжүүлж, ажлын үр дүнг тооцон ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг сараар гаргаж батлуулан, хяналт шалгалтын ажлыг тодорхой хэсэг дээр зохион байгуулж ажилласан байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2,603,082.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 52,061.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн суурь үзүүлэлт нийт зардлын 2,469,477.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцож 49,389.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Могойн гол ХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 957,928.2 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	80,596.5	146,272.3	65,675.8
Авлага	373,466.3	303,910.1	-69,556.2
Урьдчилгаа		96,100.0	96,100.0
Бараа материал	2,963,773.7	3,769,174.4	805,400.7
Бусад эргэлтийн хөрөнгө	26,108.5	24,766.7	-1,341.8
Үндсэн хөрөнгө	1,806,019.2	1,867,668.8	61,649.6

**Могойн гол ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

Нийт хөрөнгийн дүн	5,249,964.2	6,207,892.4	957,928.2
Өр төлбөр	2,118,137.7	2,423,122.4	304,984.7
Эздийн өмч	3,131,826.5	3,784,769.9	652,943.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,249,964.2	6,207,892.4	957,928.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 146,272.3 мянган төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 303,910.1 мянган төгрөг болж 69,556.2 мянган төгрөгөөр буурсан байна. Санхүүгийн тайланд байгууллагаас авах авлагын 412,122.1 мянган төгрөгөөс найдваргүй авлагын нөөц 121,482.0 мянган төгрөгийг хассан цэвэр дүнгээр толилуулсан байна. Авлага дансны үлдэгдэлд 2001-2009 онуудад үүссэн, он удаан жил болсон 28 байгууллагын 48,919.1 мянган төгрөгийн авлага нь барагдах боломжгүй эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,769,174.4 мянган төгрөг болж 805,400.7 мянган төгрөгөөр өссөн нь материаллаг нөлөө үзүүлсэн бэлэн бүтээгдэхүүн дансны 2,648,391.4 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй, дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 580,447.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ. Энэ нь нүүрсний борлуулалтын хэмжээ 50 хувиар буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,867,668.8 мянган төгрөг болж 61,649.6 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр капиталжуулсан барилга байгууламж 10,621.1 мянга, машин тоног төхөөрөмж 18,181.8 мянга, дуусаагүй барилга байгууламж данс 6,138.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Биет бус хөрөнгө дансанд 125,466.8 мянган төгрөгөөр газар эзэмших эрхийг үнэлж данс бүртгэлд тусгасан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1,375,789.2 мянган төгрөг болж 559,097.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд барилга байгууламжийг 559,097.5 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн байна

Тайлант хугацаанд хуримтлагдсан элэгдэл дансанд 657,856.2 мянган төгрөгийн өөрчлөлт гарсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,423,122.4 мянган төгрөг болж 304,984.7 мянган төгрөгөөр өссөн нь материаллаг нөлөө үзүүлсэн богино хугацаат зээл 336,257.2 мянган төгрөг байна. Энэ нь бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангах, эргэлтийн хөрөнгийг дэмжих зорилгоор ХААН банкнаас 1 жилийн хугацаатай 500,000.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл авсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 1978 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Засгийн газарт буцаан төлөх гэрээгээр олгосон зээлийн үлдэгдэл 346,536.2 мянга төгрөг, 2001 онд Япон улсын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх нөхцөлтэй 5-н жилийн хүүгүй зээлийн үлдэгдэл 448,991.1 мянган төгрөгийн урт хугацаат төлбөр байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл төрийн өмч 42,310.7 мянган төгрөг, хувьцаа эзэмшигчдийн өмч 40,651.5 мянган төгрөг байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 202,833.3 мянган төгрөг байна.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Могойн гол ХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

**Могойн гол ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

Тайлант оны нийт орлогыг 7,365,099.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 6,995,558.2 мянган төгрөгөөр, ашгийг 369,541.1 мянган төгрөгөөр тогтоосон ба 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар тодотгол хийж, нийт орлогыг 5,019,099.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,855,198.9 мянган төгрөгөөр, ашгийг 163,900.4 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 2,577,066.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,469,477.2 мянган төгрөгийн зардал гарган, 107,588.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь нүүрсний борлуулалтын орлого 2,531,804.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 45,216.7 мянган төгрөгөөс бүрджээ.

Хүснэгт 2. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
	Хөрс хуулалт /мян.м3/	мян.м3	1,003.8	1,039.7	1,040.5	(0.80)	100.1
	Олборлох нүүрсний хэмжээ	мян.тн	130.0	110.0	75.0	35.00	68.2
	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	82.9	110.0	62.8	47.20	57.1
2	Нийт орлого		3,276,248.3	5,019,099.3	2,577,066.1	2,442,033.20	51.3
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	3,173,376.8	4,922,000.0	2,531,804.4	2,390,195.60	51.4
	Туслах үйл ажиллагааны орлого	мян.төг	102,871.5	97,099.3	45,261.7	51,837.60	46.6
3	Нийт зардал	мян.төг	2,528,286.1	4,855,198.9	2,469,477.2	2,385,721.70	50.9
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	2,114,019.6	3,893,687.2	2,119,004.2	1,774,683.00	54.4
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	355,342.6	416,559.3	283,207.3	133,352.00	68.0
	в) Бусад зардал	мян.төг					
	г) Хөрөнгө оруулалт их засвар	мян.төг					
4	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	747,962.2	163,900.4	107,588.9	56,311.50	65.6

Могойн гол ХК 2020 онд 1,040.5 мянган м³ хөрс хуулалтын ажил хийж, 75.0 мян.тн нүүрс олборлож орон нутагт 62.8 мян.тн нүүрс борлуулсан байна. Өнөөдрийн байдлаар уурхайд 50.0 мян.тн авахад бэлэн нүүрсний нөөц хуримтлагдсан бөгөөд нүүрсний экспортыг хориглосонтой холбоотойгоор эдийн засгийн эргэлтэд орох боломжгүй үлдэгдэлтэй байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,577,066.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,442,033.2 мянган төгрөг буюу 48.7 хувиар тасарсан нь Аймгийн ИТХ-ын ээлжит бус 10 дугаар хуралдааны 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нүүрсний экспортыг хориглосон шийдвэр гарснаас Булган Эрдэнэтийн чиглэлийн авто замаар

экспортын нүүрс тээвэрлэх үйл ажиллагаа бүрэн зогсож нүүрсний борлуулалтын хэмжээ 50 хувиар буурч компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,469,477.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 2,385,721.7 мянган төгрөг буюу 50.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь борлуулалтын орлого буурсантай холбоотойгоор борлуулсан бүтээгдэхүүний өртөг 1,774,683.0 мянган төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд санхүүжилт төлөвлөөгүй байна.

Тайлант онд цэвэр ашиг 107,588.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 56,311.3 мянган төгрөгөөр дутуу байгаа нь орлого 48.7 хувиар дутуу биелснээс шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

ТУЗ-ийн шийдвэрийн дагуу тайлант онд өмнөх оны ногдол ашгаас 10,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл 3, орон нутгийн төлөөллийг хэрэгжүүлэгч 3, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 8 удаа зохион байгуулж 37 асуудлыг хэлэлцэн 10 асуудлыг мэдээлэл хэлбэрээр сонсож, 27 тогтоол шийдвэр гарган ажиллсасан байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой журмыг шинэчлээгүй байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 140,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 67,614.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшуулал, шимтгэлийн зардалд 57,619.3 мянга, томилолтын зардалд 823.9 мянга, бичиг хэргийн зардалд 1,377.1 мянга, тээвэр шатахуун 2,477.5 мянга, хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал 2,135.5 мянга, ТУЗ-ийн хурлын зардал 1,521.2 мянга, бусад зардалд 1.659.5 мянга төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 62 мэдээллээс 56 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт / сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	6	258,713.1	6	258,713.1	
Нийт дүн	6	258,713.1	6	258,713.1	

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 349,412.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 308,185.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 41,226.3 мянган төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Балансын дансдын үлдэгдлийг шалгаж үзэхэд урьдчилж орсон орлого 134,582.9 мянга, урьдчилж гарсан зардал, төлбөр 96,100.0 мянга, найдваргүй авлагын нөөцийг 2,887.3 мянга нийт 233,570.2 мянган төгрөгөөр буруу бүртгэснийг аудитын хугацаанд залруулав.
2. Мөнгөн гүйлгээний тайлангийн мөнгөн орлого болон зарлагын дүн нь касс, харилцах дансдын орлого, зарлагын гүйлгээний нийт дүнгээс 61,698.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг аудитын хугацаанд залруулав.
3. 11,12 сарын зээлийн эргэн төлөлтийг үндсэн төлбөр, хүүгийн зардал гэж ангилж бүртгэхгүйгээр нийт дүнгээр нь зээлийн үндсэн төлбөрийг 12,917.2 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасныг аудитын хугацаанд залруулав.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Могойн гол ХК-д 50.0 мян.тн авахад бэлэн нүүрсний нөөц хуримтлагдсан бөгөөд үүнийг мөнгөн дүнгээр илэрхийлэхэд 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгө эдийн засгийн эргэлтэд орох боломжгүй нөхцөл байдалд байна. Нүүрсийг олборлоод жил өнжиж цаг хугацаа алдсанаар нүүрс өгөршилд орж коксжих чанарын үзүүлэлт буурч шаардлага хангахгүй болдог учир бэлэн нүүрсний үлдэгдлийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын авлага дансанд 2001-2009 онд үүссэн 28 байгууллагын 48,919.1 мянган төгрөгийн одоог хүртэл барагдуулаагүй авлага, 2017 онд Мон маг ХХК-аас худалдан авсан 5,519.4 мянган төгрөгийн тэсрэх материал нь хугацаа дууссан чанарын шаардлага хангаагүй улмаас төлбөрийг шилжүүлээгүй өглөг, 2018 онд Багануур ХХК-аас 4,972.0 мянган төгрөгийн өрмийн сэлбэг авч шаардлага хангаагүй тул төлбөрийг шилжүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Компаний тухай хуулийн 84.4.3 "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" заалтуудтай, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Авлага, өглөг ихээр үүсэх нь компанийн санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадвар алдагдах, хөрөнгө шамшигдах эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Компаний тухай хуулийн 84.4.3 "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" дахь заалтуудыг үндэслэн ТУЗ-өөр хэлэлцүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2. Зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Орлогын тайланд үйл ажиллагааны бус зардал 29,840.9 мянган төгрөгийг татварын өмнөх ашгийг нэмэгдүүлж орлогын албан татварын зардлыг тооцоогүй тайлант үеийн цэвэр ашгийг 29,840.9 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан, өмчийн өөрчлөлтийн тайланд үйл ажиллагааны бус зардлын татварын өглөгийг өмнөх үеийн үр дүнг 2,984.1 мянган төгрөгөөр бууруулж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" дахь заалттай нийцэхгүй "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, удирдлагыг буруу мэдээллээр хангах

2.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" дахь заалтыг хэрэгжүүлэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг төлөвлөхдөө үйл ажиллагааны бус зардлыг татварын өмнөх ашгийг нэмэгдүүлж орлогын албан татварын зардлыг төлөвлөх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Өөрийн байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн шинэчлэн, мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана."-ыг мөрдөөгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт хэрэгжихгүй байх, нягтлан бодох бүртгэлийг зохион байгуулахад ойлгомжгүй асуудал үүсэх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 заалтад заасны дагуу өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөх.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Анхан шатны баримттай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Касс, харилцахын баримтын анхан шатны баримтын бүрдлийг шалгахад 37 ширхэг 8,401.3 мянган төгрөгийн бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөлд 1 болон 2-р гарын үсэггүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" дахь заалттай нийцэхгүй "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл: Бэлэн мөнгө шамшигдах зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлтэй

4.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын мөрдөж хуулийн хүчин төгөлдөр баримтаар гүйлгээ хийх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

5. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжтай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тухайн байгууллагад ашиглагдаж байгаа "Венница" НББ-ийн програм хангамж нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамтай уялдаагүй "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, удирдлагыг буруу мэдээллээр хангах

5.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн яамнаас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан програм хангамжаар НББ-ийг хөтөлж тайлан гаргах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

6. Балансын данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Бараа материалыг төрөлжүүлж ангилж бүртгээгүй түүхий эд материал дансанд дизель түлш болон тэсрэх бодисуудыг нийлүүлэн бүртгэсэн, аж ахуйн материалын дансанд хүнсний бүтээгдэхүүнийг бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан тодруулга бэлтгэх заавар”-ын 2 дугаар бүлэгт заасан “Аж ахуйн нэгж бүр өөрийн үндсэн үйл ажиллагааны шинж чанарт үндэслэн хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд ангилан, тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон толилуулна” –тай нийцэхгүй “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна

6.2. Эрсдэл: Санхүүгийн тайлангийн мэдээлэл буруу илэрхийлэгдэх

6.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан тодруулга бэлтгэх заавар”-ын 2 дугаар бүлэгт заасан “Аж ахуйн нэгж бүр өөрийн үндсэн үйл ажиллагааны шинж чанарт үндэслэн хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд ангилан, тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон толилуулна”-ыг хэрэгжүүлж, бараа материалыг ангилан төрөлжүүлж данс бүртгэлд тусгах.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

7. Дотоод хяналттай холбоотой асуудал

7.1 Илрүүлэлт:

Авлага өглөгийн тулган баталгаажуулалтаар 68,848.7 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалттай нийцэхгүй “үнэн зөв байдал” батламж мэдэгдэл хангахгүй байна.

7.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, өр авлага үүсэх, холбогдох стандарт, хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байх;

7.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох байгууллагатай өглөг, авлагын тооцоо нийлж баталгаажуулах;

7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр: Могойн гол ХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: ХӨА-2021/7/СТА-ОНӨААН
Шалгагдсан байгууллагын нэр: Могойн гол ХК		Саяг төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус байгууллагын авлага дансанд 2001-2009 онд үүссэн 28 байгууллагын 48,919.1 мянган төгрөгийн одоог хүртэл барагдуулаагүй авлага, 2017 онд Мон маг ХХК-аас худалдан авсан 5,519.4 мянган төгрөгийн тэсрэх материал нь хугацаа дууссан чанарын шаардлага хангаагүй улмаас төлбөрийг шилжүүлээгүй өглөг, 2018 онд Багануур ХХК-аас 4,972.0 мянган төгрөгийн өрмийн сэлбэг авч шаардлага хангаагүй тул төлбөрийг шилжүүлээгүй байна.	0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Нягтлан бодогч	О.Ууганбаяр Д.Тайванцэцэг
2	Орлогын тайланд үйл ажиллагааны бус зардал 29,840.9 мянган төгрөгийг татварын өмнөх ашгийг нэмэгдүүлж орлогын албан татварын зардлыг тооцоогүй тайлант үеийн цэвэр ашгийг 29,840.9 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан, өмчийн өөрчлөлтийн тайланд үйл ажиллагааны бус зардлын татварын өглөгийг өмнөх үеийн үр дүнг 2,984.1 мянган төгрөгөөр бууруулж бүртгэсэн.	32,825.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Нягтлан бодогч	О.Ууганбаяр Д.Тайванцэцэг
3	Өөрийн байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн шинэчлэн, мөрдөөгүй		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Нягтлан бодогч	О.Ууганбаяр Д.Тайванцэцэг
4	Касс, харилцахын баримтын анхан шатны баримтын бүрдлийг шалгахад 37 ширхэг 8,401.3 мянган төгрөгийн бэлэн мөнгө	8,401.3	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран	О.Ууганбаяр Д.Тайванцэцэг

Могойн гол ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	олгохыг хүссэн өргөдөлд 1 болон 2-р гарын үсэггүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гүйлгээ хийсэн			гүйцэтгэгч Нягтлан бодогч	
5	Тухайн байгууллагад ашиглагдаж байгаа “Венница” НББ-ийн програм хангамж нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамтай уялдаагүй		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Нягтлан бодогч	О.Ууганбаяр Д.Тайванцэцэг
6	Бараа материалыг төрөлжүүлж ангилж бүртгээгүй түүхий эд материал дансанд дизель түлш болон тэсрэх бодисуудыг нийлүүлэн бүртгэсэн, аж ахуйн материалын дансанд хүнсний бүтээгдэхүүнийг бүртгэсэн		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Нягтлан бодогч	О.Ууганбаяр Д.Тайванцэцэг
	Авлага өглөгийн тулган баталгаажуулалтаар 68,848.7 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Нягтлан бодогч	О.Ууганбаяр Д.Тайванцэцэг
дүн		41,226.3			

Сангийн сайдын 2017 оны
361 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт

Регистрийн дугаар: 2 0 3 4 8 5 9

Хаяг: Хөвсгөл аймаг цэцэрлэг сум
Утас: 88106430. 88109340
Өмчийн хэлбэр: Төрийн 51 %

Шуудангийн хаяг:.....
Факс:.....
Хувийн 49 %

А маягт

Могойн гол ХК-ийн 2020 оны 4-р улирлын санхүүгийн тайлан

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар өдөр	Гарын үсэг

Могойн гол ХК-ийн
2020 оны санхүүгийн тайлангийн
бодит байдлын тухай мэдэгдэл

2021 оны 02-р сарын 10 өдөр

Захирал Отгонбаяр овогтой Ууганбаяр ерөнхий нягтлан бодогч Даваасамбуу овогтой Тайванцэцэг бид манай аж ахуйн нэгжийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд, тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 17.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлаж бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн.
3. Аж ахуйн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан.
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй.
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан.
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.



Захирал

/О.Ууганбаяр/

Ерөнхий нягтлан бодогч *Отгонбаяр* Тайванцэцэг/

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Бэлтгэсэн огноо: 2021/03/15 4:28:57 PM

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	80,596,465.28	146,272,287.03
1.1.02	Дансны авлага	350,667,391.97	290,640,137.70
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.04	Бусад авлага	22,798,893.00	13,269,989.37
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.06	Бараа материал	2,963,773,734.49	3,769,174,445.62
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	96,100,000.00
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	26,108,512.71	24,766,738.63
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	0.00	0.00
1.1.10		0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,443,944,997.45	4,340,223,598.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.01	Үндсэн хөрөнгө	1,778,621,836.82	1,742,201,970.37
